МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ПАРЛАМЕНТЫН ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА ДУУСГАВАР БОЛСОН ТОХИОЛДОЛД ОЛГОДОГ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

Судалгааны төрөл: Харьцуулсан судалгаа

Судалгааны код: **СТ-25/250**

Хугацаа: **2025.11.11**

Захиалагч:	Өргөдлийн байнгын хорооны дарга, УИХ-ын гишүүн О.Номинчимэг
Хянасан:	Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Гэсэр
Судалгаа удирдсан:	Судалгааны хэлтсийн зөвлөх Г.Билгээ
Судлаач:	Судалгааны хэлтсийн ахлах референт О.Нарантуяа

Улаанбаатар хот
2025 он

УДИРТГАЛ

“Парламентын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тохиолдолд олгодог санхүүгийн дэмжлэгийн талаарх харьцуулсан судалгаа”-г Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн (ПСХХ)-д гүйцэтгэв.

Судалгааны зорилго:

Энэхүү судалгааны зорилго нь парламентын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсноор дараагийн ажил, албан тушаал эрхлэх хүртэлх завсарын хугацаанд олгох санхүүгийн дэмжлэгийн талаар гадаад улсуудын зохицуулалтын талаар харьцуулсан судалгаа гаргах.

Судалгааны хамрах хүрээ:

Судалгаанд парламентын гишүүн сонгуульд нэр дэвшээгүй, дахин сонгогдоогүй, эсхүл бусад шалтгаанаар бүрэн эрх нь дуусгавар болсон тохиолдолд санхүүгийн дэмжлэг олгодог эсэх, ямар хугацаанд, ямар хэмжээтэй олгодог болон тэтгэмж, дэмжлэг олгодог шалгуур, нөхцөлийн талаар гадаад улсуудын туршлагыг судлав.

Судалгааны арга зүй:

Судалгаанд сонгож авсан улсуудын холбогдох хууль тогтоомжийг харьцуулан судлах үүднээс харьцуулсан шинжилгээний арга зүй, хууль зүйн баримт бичгийн судалгааны аргыг ашигласан болно.

Түлхүүр үг:

Монгол: *тэтгэмж, дэмжлэг, нөхөн олговор, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, сонгуульд нэр дэвшээгүй, дахин сонгогдоогүй, санхүүгийн дэмжлэг.*

Англи: *resettlement grant, loss of office payment, severance payment, transitional payment, termination payment, separation payment, supplementary remuneration, financial redeployment support*

Парламентын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тохиолдолд олгодог санхүүгийн дэмжлэг

Парламентын гишүүний бүрэн эрх дуусгавар болсны дараах тэтгэмж, нөхөн олговор зэрэг санхүүгийн дэмжлэгийн эрх зүйн зохицуулалтыг судлав.

Судалгаанаас үзэхэд, парламентын гишүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зохицуулалт улс бүрт ялгаатай боловч нийтлэг хоёр чиг хандлага ажиглагдаж байна. Баруун Европын ихэнх улсад дахин сонгогдоогүй, эсхүл сайн дураар огцорсон гишүүнд хөдөлмөрийн зах зээлд эргэн шилжих, орлогогүй хугацааг нөхөх зорилгоор хугацаатай тэтгэмж/цалин олгож байна. Харин Азийн орнуудад парламентын гишүүдэд зориулсан тусгай эдийн засгийн дэмжлэг байхгүй, ерөнхий нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулж зохицуулах нь түгээмэл байна. Тухайлбал, Энэтхэг Улс парламентын гишүүнээр ажиллаж байгаад бүрэн эрх нь дуусгавар болсон тохиолдолд насан туршид нь тэтгэвэр олгодог. Харин Сингапур Улс 2012 онд Парламентын тэтгэврийн тухай хууль (Parliamentary Pensions (Abolition) Act)[1]-ийг баталснаар парламентад 8 жил ба түүнээс дээш хугацаагаар ажилласан гишүүдэд үндсэн цалингийн тодорхой хувиар олгодог байсан нэг удаагийн тэтгэмжийн зохицуулалтыг хүчингүй болгожээ.

Судалгаанд хамрагдсан улсуудад парламентын сонгуульд дахин сонгогдоогүй, дахин нэр дэвшээгүй зэрэг шалтгаанаар бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тохиолдолд нэг удаагийн нөхөн олговор (Ирланд, Их Британи, Гана, Канад) ба сараар олгох шилжилтийн урамшуулал/тэтгэмж (Австрали, Австри, Герман, Дани, Норвеги, Швед) гэсэн хоёр үндсэн хэлбэр байна.

Эдгээр нөхөн олговор, тэтгэмжийг ихэвчлэн суурь цалинтай дүйцүүлэх, эсхүл тодорхой хувиар тооцдог бөгөөд нэршлийн хувьд улс бүрт өөр өөр байна. Жишээлбэл, шилжин суурьших нэг удаагийн тэтгэмж (resettlement grant), албан тушаалаа алдсаны нөхөн олговор (loss of office payment), ажлаас халагдсаны тэтгэмж (severance payment), шилжилтийн тэтгэмж/төлбөр (transitional payment), бүрэн эрх дуусгавар болсоны төлбөр (termination payment), ажлаас чөлөөлөгдөх үеийн тэтгэмж (separation payment), цалин хөлсний нэмэгдэл (supplementary remuneration) болон албан тушаалын дахин байршуулалтын санхүүгийн дэмжлэг (financial redeployment support) гэсэн нэр томьёог хэрэглэж байна.

Тавигдах нөхцөл, шаардлагын хувьд, хамгийн бага ажилласан хугацаа (6 сар, 1 жил), дахин сонгогдоогүй, эсхүл нэр дэвшээгүй байх, өргөдөл гаргах, ажил идэвхтэй хайж байх, эсхүл сургалтад хамрагдах зэрэг шалгуур тавьдаг байна. Судалгаанд хамрагдсан улсуудын товч мэдээллийг Хүснэгт 1-ээс, дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 2-оос үзнэ үү.

[1] Сингапур: Parliamentary Pensions (Abolition) Act (2012), Хандах: https://www.parliament.gov.sg/docs/default-source/Bills-Introduced/parliamentary-pensions-(abolition)-bill-18-2012.pdf#:~:text=21st%20May%202011%203,in%20respect%20of%20%E2%80%94%204

Хүснэгт 1.Судалгааны хамрагдсан улсуудын товч тойм

№	Улсын нэр	Санхүүгийн дэмжлэг	Нэг хүнд ногдох ДНБ (US$)	Дэмжлэгийн хэмжээ (сараар, ойролцоогоор, US$)	Олгох хугацаа
1	**Австрали**	Түр хугацааны тэтгэмж	64,407	12,647	1 удаа сонгогдсон гишүүнд 3 сар, хоёр ба түүнээс дээш удаа сонгогдсон гишүүнд 6 сар
2	**Австри**	Бүрэн эрх дуусгавар болсноор олгох төлбөр	56,833	7,300	3–6 сар
3	**Гана**	Нэг удаагийн тэтгэмж	2,405	43,000	нэг удаагийн тэтгэмж
4	**Герман**	Шилжилтийн тэтгэмж	55,800	13,688	1 бүрэн эрхийн хугацаанд ажилласан бол 4 сар, дээд хугацаа 18 сар хүртэл;
5	**Дани**	Нэмэлт урамшуулал	71,851	10,327	6–24 сар
6	**Ирланд**	Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсны төлбөр	107,316	7,773	нэг удаагийн төлбөр; нэмэлт хугацаат төлбөр авах боломжтой.
7	**Их Британи**	Албан тушаалаа алдсаны нөхөн олговор	52,636	7,000-36,000	Нэг удаагийн нөхөн олговор
8	**Канад**	Шилжилтийн дэмжлэг	54,282	15,000	нэг удаа
9	**Норвеги**	Ажлаас халагдсаны тэтгэмж	86,809	9,965	3 сар 100%, тодорхой нөхцөлд 1 жил хүртэл 66%
10	**Швед**	Санхүүгийн дэмжлэгийг	57,723	7,900	2 жил хүртэл; эхний үед 85%, сунгасан тохиолдолд 45%
11	**Энэтхэг**	Тэтгэвэр	2,696	282+22	Хугацаагүй

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан улсуудын мэдээлэлд тулгуурлан судлаачийн боловсруулснаар.

Хүснэгт 2. Парламентын гишүүний бүрэн эрх дуусгавар болсны дараа санхүүгийн дэмжлэг олгодог улс орнууд

№	Улсын нэр / Нэг хүнд ногдох ДНБ	Зохицуулалтын эрх зүйн үндэс	Олгох хугацаа	Олгох хэмжээ	Тавигдах шалгуур	Тайлбар
1	**Австрали** Нэг хүнд ногдох ДНБ 64,407 US$ (2024)[2]	Парламентын гишүүдийн нөхөн дэмжлэгийн схем 101 дүгээр зүйл (Parliamentary Contributory Superannuation Act 1948, Resettlement Allowance)[3]	Австралийн Холбооны Парламентын гишүүдэд **“resettlement allowance”** хэмээх тэтгэмжийг нэг удаа олгодог. Нэг удаа сонгогдсон гишүүнд 3 сар, хоёр ба түүнээс дээш удаа сонгогдсон гишүүнд 6 сар олгоно.	Тэтгэмжийн хэмжээнь үндсэн цалингийн 6 сарын хэмжээтэй тэнцүү буюу 116,830 AUD (буюу 72,000 ам.доллар) байна. 2024 оны байдлаар Парламентын гишүүний жилийн үндсэн цалин 233,660 буюу сарын цалин 19,470 австрали доллар[4] (ойролцоогоор сарын 12,647 ам.доллар) байна.	–2004 оны 10 дугаар сарын 9-ний өдрөөс өмнө анх сонгогдсон байх; –Парламентын нэмэлт тэтгэврийн схемээр тэтгэврийн эрх үүсээгүй байх; –сонгуульд нэр дэвшиж чадаагүй (улс төрийн дэмжлэг намаас авч чадаагүй), сонгуульд ялагдсан тохиолдолд хамаарна;	Тэтгэмжид орлогын албан татвар тооцогдоно[5].

[2] Энэхүү судалгаанд хамрагдсан улсуудын нэг хүнд ногдох ДНБ-ний мэдээллийг Дэлхийн банкны мэдээллийн сангаас авч ашигласан болно. Хандах: https://data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.CD?locations=AU-AT-DE-GH-DK-IE-CA-NO-SE-GB&name_desc=false&utm_source=chatgpt.com, Хандсан: 2025-11-10.

[3] Австрали: Parliamentary Contributory Superannuation Act 1948, Resettlement Allowance. Хандах: https://publications.parliament.uk/pa/cm5803/cmselect/cmadmin/209/report.html#:~:text=107,are%20entitled%20to%20a%20severance

[4] Олон Улсын Парламентын холбоо (IPU), Австрали. Хандах: https://data.ipu.org/parliament/AU/AU-UC01/parliamentary-mandate/parliamentary-mandate/

[5] Австрали: Commonwealth parliamentarians pay and remuneration: Survey outcome report 2020-2021, 59 дэх тал. Хандах: https://www.cpahq.org/media/1z3fwmeu/cpa-members-remuneration-report-2020-2021-final.pdf#:~:text=The%20type%20of%20allowance%20is,so%2C%20are%20these%20payments%20taxed

					–ажлын байр хайх зорилгоор мэдэгдэл гаргасан байх; –өөрийн хүсэлтээр дараагийн сонгуульд нэр дэвшээгүй бол уг тэтгэмжийг олгодоггүй. (Parliament of Australia, 2022)	
2	**Австри** Нэг хүнд ногдох ДНБ 56,833 US$ (2024)	Холбооны цалингийн тухай хууль 6 дугаар зүйл. Үйл ажиллагаа дуусгавар болсны дараа төлбөрийг үргэлжлүүлэх (Federal Emoluments act[6], 2nd Section, Continuation of payment after termination of function)	Албан тушаалын бүрэн эрх дуусгавар болсноор олгох төлбөр **(termination payment)**-ийг дараах хугацаанд олгоно: –өөр ажил, албан тушаал эрхлэхийг хориглосон бол 6 сар; –бусад байгууллагын хувьд 3 сар.	Сарын цалингийн 75 хувиар олгоно. Үндэсний зөвлөлийн гишүүний үндсэн цалин 2024 оны байдлаар жилийн 75811[7] евро буюу сарын 6317 евро (ойролцоогоор сарын 7300 ам.доллар) байна. Төлбөрийг орлогоос хамаарч бууруулах бөгөөд ажилд орсон тохиолдолд уг төлбөрийг зогсооно.	–Албан тушаалын бүрэн эрх дуусгавар болсон байх; –өргөдөл гаргасан байх.	Энэ хуулийн үйлчлэл нь Холбооны Ерөнхийлөгч, Холбооны Засгийн газрын гишүүд, Төрийн нарийн бичгийн дарга нар, Аудитын шүүхийн дарга, Үндэсний зөвлөлийн гишүүдэд мөн хамаарна.
3	**Гана**	Үндсэн хууль	Гишүүний ажилласан	Тэтгэмжийн хэмжээг Ерөнхийлөгч нь	–Ямар ч хугацаанд гишүүнээр	Гана Улсын Үндсэн хуулийн 114 дүгээр

[6] Австри: Federal Emoluments act (1997/2015). Хандах: https://www.parlament.gv.at/en/explore/making-laws/legal-bases/page/index.html#:~:text=%C2%A7%206,after%20termination%20of%20function

[7] Олон Улсын Парламентын холбоо (IPU), Австри. Хандах: https://data.ipu.org/parliament/AT/AT-UC01/parliamentary-mandate/parliamentary-mandate/

	Нэг хүнд ногдох ДНБ 2,405 US$ (2024)	114 дугаар зүйл The Constitution of the Republic of Ghana (1992)[8]	хугацаанд дүйцүүлсэн нэг удаагийн тэтгэмж **(gratuity)** олгоно. Тодорхой хугацаа заагаагүй.	Үндсэн хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн байгуулсан Цалин хөлс, урамшууллын хороотой зөвшилцөж тогтооно. (Албан бус мэдээллийн хэрэгслээр тэтгэмжийн хэмжээг 464,000 гана седи буюу 43,000 ам.доллар байсан (Ghana News, 2025).	сонгогдсон байж болно; –зөвхөн нас барсан, бүрэн эрхийн хугацаа дууссан, сонгуулийн дүнгээр дахин сонгогдоогүй, сайн дураар огцорсон бол. –дахин гишүүнээр сонгогдсон хэдий ч уг тэтгэмжийг авдаг онцлогтой.	зүйлд зааснаар, Парламентын гишүүнээр ажиллах эрхээс хасагдсан, эсхүл түүний суудал Үндсэн хуулийн 97 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (c), эсхүл (d)-д заасан (гүйцэтгэх засаглалын албан тушаалд томилогдсон, эсхүл эрүүгийн ял авсан) үндэслэлээр сул орон гарсан тохиолдолд нэг удаагийн тэтгэмж авах эрх үүсэхгүй.
4	**Герман** Нэг хүнд ногдох ДНБ 55,800 US$ (2024)	Бундастагийн гишүүний эрх зүйн байдлын тухай хууль (Abgeordnetengesetz – 18 дугаар зүйл[9]	Бундестагийн гишүүний бүрэн эрх нь дуусгавар болсны дараа шилжилтийн тэтгэмж (**transitional emoluments**) авах эрхтэй. Тэтгэмжийг нэг удаа, эсхүл сар бүр авч болох бөгөөд	Тэтгэмжийн хэмжээг одоогийн Бундестагийн гишүүний цалин хөлсний хэмжээгээр тооцож олгоно. Бундестагийн гишүүний цалин 2025 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар жилийн	–Дор хаяж нэг жил ажилласан байх; –хуурамч мэдээлэл өгөөгүй байх, –төрийн бус байгууллагаас нөхөн олговор аваагүй байх.	Тэтгэмж нь хууль тогтоох ажилтны иргэний амьдралд шилжихэд туслах зорилготой.

[8] Гана: The Constitution of the Republic of Ghana
https://www.icla.up.ac.za/images/constitutions/ghana_constitution.pdf#:~:text=%E2%80%9CGratuties%20for
[9] Герман: Abgeordnetengesetz, Хандах: https://www.gesetze-im-internet.de/abgg/

		(Transitional emoluments)[10])	гишүүний ажилласан жил бүрт нэмэгдүүлэн тооцно. Нэг сонгуулийн бүрэн эрх (4 жил) ажилласан гишүүн дөрвөн сарын хугацаанд тэтгэмж авна. Тэтгэмжийг олгох дээд хугацаа 18 сар байна.	142,001.64 евро [11] буюу сарын 11,833.47 евро (ойролцоогоор сарын 13,688 ам.доллар) байна.		
5	**Дани** Нэг хүнд ногдох ДНБ 71,851 US$ (2024)	Парламентын сонгуулийн тухай хууль 109 дүгээр зүйл (Parliamentary Election Act[12])	Гишүүн 6 сар тасралтгүй ажилласны дараа Парламентын гишүүний ажлаа хүлээлгэн өгвөл 6-24 сар хүртэл хугацаанд нэмэлт урамшуулал (**transitional remuneration**) авна.	Нэмэлт урамшууллын хэмжээ нь нэг сарын үндсэн цалинтай тэнцүү байна. Нэмэлт урамшууллын хугацаа нь нэг жил ажилласан бол 6 сар, дөрвөн жил ажилласан бол 24 сар байна[13].	–Дор хаяж 6 сар тасралтгүй ажилласан байх; –илүү орлоготой бол нэмэлт урамшууллын хэмжээ буурна; –сургалтын дэмжлэг авах бол бусад нэмэлт	Нэмэлт урамшууллыг Парламентын сонгуулийн дараа дахин сонгогдоогүй, намын дэмжлэг аваагүй, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар огцорсон гишүүдэд олгоно.

[10] Герман: Bundastag. Хандах: https://webarchiv.bundestag.de/archive/2007/0625/htdocs_e/members/remuneration/transit.html#:~:text=One%20month%20of%20transitional%20allowance,off%20against%20this%20transitional%20allowance

[11] Герман: Deutscher Bundestag. Хандах: https://www.bundestag.de/abgeordnete/mdb_diaeten/mdb_diaeten-214848?utm_source=chatgpt.com, Хандсан: 2025-11-10.

[12] Дани: Parliamentary Election Act (1988/2016). Хандах: https://www.elections.im.dk/parliament-elections/folketing-parliamentary-elections-act

[13] Дани: Loss of office and Transitional Support: Parliamentary comparison (2024). Хандах: https://remunerationboard.wales/media/j1kj3glq/loss-of-office-and-transitional-support-parliamentary-comparison.pdf#:~:text=Denmark%20Provision%20for%20the%20remuneration,35

				2024 оны байдлаар Парламентын гишүүний жилийн цалин 801,037 дани крон[14] буюу нэг сарын цалин 66,753 дани крон (ойролцоогоор 10,327 ам.доллар) байна.	урамшууллыг бууруулахгүй.	
6	**Ирланд** Нэг хүнд ногдох ДНБ 107,316 US$ (2024)	Ажлаас халагдсаны төлбөр (Termination payments[15])	Албан тушаал эрхлэхээ больсон тохиолдолд албан тушаалын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсны төлбөр (**termination payments**)-ийг нэг удаа олгоно.	Хоёр сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн төлбөр олгоно. Энэ төлбөр нь Татварын хорооны (Revenue Commissioners) тусгай дүрмээр зохицуулагдана. Парламентын гишүүний нэг жилийн цалин 2025 оны байдлаар 81,206 евро[16] буюу сарын 6,727 евро (ойролцоогоор	**Нэг удаагийн төлбөр:** –Парламентын гишүүнээр тасралтгүй дор хаяж 6 сарын хугацаанд ажилласан байх; –дараагийн Парламентын гишүүнээр дахин сонгогдоогүй, Европын парламентын гишүүн (MEP) болоогүй, эсхүл Засгийн газраас бүтэн цагийн албан тушаалд томилогдоогүй байх.	Гишүүн огцрох буюу суудлаа алдах үедээ тодорхой нөхцөлийн дагуу тэтгэврийн эрх нээгдэхээс өмнө нэг удаагийн төлбөр болон хугацаат нөхөн төлбөр авна. Гишүүн нь нэгэн зэрэг төлбөр болон тэтгэвэр авч болохгүй.

[14] Олон Улсын Парламентын холбоо (IPU), Дани. Хандах: https://data.ipu.org/parliament/DK/DK-LC01/parliamentary-mandate/parliamentary-mandate/
[15] Ирланд: Termination payments. Хандах: https://www.oireachtas.ie/en/working-in-parliament/pensions/termination-payments/
[16] Олон Улсын Парламентын холбоо (IPU), Ирланд. Хандах: https://data.ipu.org/parliament/IE/IE-UC01/parliamentary-mandate/parliamentary-mandate/

				сарын 7,773 ам.доллар) байна.	**Хугацаат нөхөн төлбөр:** Нэг удаагийн төлбөрөөс гадна, гишүүн нь тасралтгүй 3 жил буюу түүнээс дээш хугацаанд ажилласан бол сар бүрийн нөхөн төлбөр авах эрхтэй. Төлбөр авах хугацаа болон хэмжээ нь тасралтгүй ажилласан жилээс хамаарна.	
7	**Их Британи** Нэг хүнд ногдох ДНБ 52,636 US$ (2024)	Гишүүдийн цалин ба зардал (Members' pay and expenses 2024/25[17], House of Commons Library)	Нийтийн танхимын гишүүн албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа албан тушаалаа алдсаны нөхөн олговор (**loss of office payment**)-ийг нэг удаа олгоно.	Албан тушаалаас чөлөөлөгдсөний нөхөн олговрын хэмжээ нь Хөдөлмөрлөх эрхийн тухай хуульд заасан тэтгэмжийг[18] хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.	–Парламентад хоёр жил тасралтгүй ажилласан байх; –сонгуульд дахин нэр дэвшээгүй (гишүүнчлэлтэй намаас улс төрийн дэмжлэг авч чадаагүй), эсхүл сонгогдоогүй байх.	Хэрэв гишүүн нь өөрийн хүсэлтээр дараагийн сонгуульд нэр дэвшээгүй тохиолдолд албан тушаалаа алдсаны нөхөн олговор олгодоггүй.

[17] Их Британи: Members' pay and expenses 2024/25, House of Commons Library research briefing. Хандах: https://researchbriefings.files.parliament.uk/documents/CBP-10225/CBP-10225.pdf#:~:text=of%20service%20subject%20to%20a,There%20would%20be%20remaining

[18] Их Британийн Хөдөлмөрлөх эрхийн тухай 1996 оны хуулийн дагуу ажил олгогч нь ажилтанаа халах тохиолдолд хууль заасан тэтгэмж олгох үүрэгтэй. Энэхүү тэтгэмж нь нас, ажилласан жил болон долоо хоногийн цалингийн дээд хэмжээ зэргийг харгалзан тогтоодог.

				Албан тушаалаас чөлөөлөгдсөн гишүүн нь хэдэн жил парламентад ажилласнаас хамаарч 7,000-36,000 ам.долларын нөхөн олговор авна (IPSA).		
8	**Канад** Нэг хүнд ногдох ДНБ 54,282 US$ (2024)	Нийтийн танхим (Parliament of Canada, House of Commons FAQs on pensions and benefits[19])	Нийтийн танхимын гишүүнээр дахин сонгогдоогүй гишүүнд шилжилтийн дэмжлэг **(transition support)**-ийг нэг удаа олгоно.	Шилжилтийн дэмжлэгийн хэмжээ 15,000 ам.доллар байна.	Сонгуулийн дараа Парламентын гишүүнээс чөлөөлөгдсөн гишүүдэд олгоно.	
9	**Норвеги** Нэг хүнд ногдох ДНБ 86,809 US$ (2024)	Стортингийн тэтгэмжийн тухай хуулийн §25 [20] Парламентын гишүүдийн цалин, тэтгэмж болон бусад зохицуулалт	Парламентын гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсноос хойш 3 сар хүртэл хугацаанд ажлаас халагдсаны тэтгэмж (**severance pay**) олгоно.	Парламентын гишүүний сарын цалинтай тэнцүү хэмжээний тэтгэмж олгоно. Тэтгэмжийг сунгасан тохиолдолд Парламентын гишүүний сарын	–Парламентын сонгуулийн дараа сонгогдоогүй байх; –өргөдөл гаргасан байх.	Ажлаас халагдсаны тэтгэмж авахын тулд тухайн хүн орлогын дэлгэрэнгүй мэдээллийг мэдүүлгийн маягтаар ирүүлнэ. Ажил идэвхтэй хайж байгаа, эсхүл

[19] Канад: Pension plan, pay and benefits of departing Members of Parliament and during dissolution of Parliament. Хандах: https://www.ourcommons.ca/Content/Newsroom/Articles/FAQsPensionSalariesBenefits-Dissolution2021-ENG%20(final).pdf

[20] Норвеги: The Storting Allowances Act (2025). Хандах: https://lovdata.no/dokument/NL/lov/2025-06-20-57/KAPITTEL_6#KAPITTEL_6

		(MPs' pay, allowances and other arrangements[21])	Тодорхой нөхцөл хангасан тохиолдолд 1 жил хүртэл сунгана.	цалингийн 66 хувь байна. 2025 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар Парламентын гишүүний жилийн 1,214,977 норвеги крон [22] буюу сарын цалин 101,248 норвеги крон (ойролцоогоор сарын 9,965 ам.доллар) байна.		ажилтай холбоотой зайлшгүй шаардлагатай сургалт, боловсрол эзэмшиж буй Парламентын гишүүн 3 сарын дараа тэтгэмжийг сунгах өргөдөл гаргаж болно. Бусад орлоготой тохиолдолд бууруулан тооцно. Өвчний тэтгэмж авч байсан тохиолдолд ажлаас халагдсаны тэтгэмжийн хугацааг тооцохдоо өвчний тэтгэмж авсан өдрийг хасч тооцно.
10	**Швед** Нэг хүнд ногдох ДНБ 57,723 US$ (2024)	Риксдагийн санхүүгийн дэмжлэг (Riksdagens finansieringsstöd)[23]	Гишүүнээс буусны дараа тус албан тушаалд ажилласан хугацаатай нь уялдуулан тогтоох бөгөөд дээд тал нь 2 жил хүртэл тус дэмжлэгийг	Дэмжлэгийн хэмжээ нь эхний үед үндсэн цалингийн 85 хувь, дэмжлэгийн хугацаа дууссаны дараа тодорхой нөхцөл хангаж, сунгасан	–Дор хаяж нэг жил ажилласан байх; –66 нас хүрээгүй байх; –тэтгэмжийг авахын тулд ажил хайх, мэргэжлийн	2014 он хүртэл "garantera ersättning" нэртэй баталгаат орлого нөхөх зорилготой байсан бол 2014 оноос хойш "financial redeployment

[21] Норвеги: MPs' pay, allowances and other arrangements. Хандах: https://www.stortinget.no/en/In-English/Members-of-the-Storting/Financial-support/#:~:text=Severance%20pay
[22] Норвеги: Stortinget. Хандах: https://www.stortinget.no/en/In-English/Members-of-the-Storting/Financial-support/#:~:text=Severance%20pay
[23] Швед: Loss of office and Transitional Support: Parliamentary comparison (2024). Хандах https://remunerationboard.wales/media/j1kj3glq/loss-of-office-and-transitional-support-parliamentary-comparison.pdf#:~:text=Denmark%20Provision%20for%20the%20remuneration,35

			(**financial redeployment support**) олгоно.	тохиолдолд 45 хувь байна. Риксдагийн гишүүний жилийн цалин 2024 оны байдлаар 906,000 буюу сарын 75,500 швед крон [24] (ойролцоогоор сарын 7900 ам.доллар) байна.	сургалтад хамрагдах зэрэг нөхцөлийг дагаж мөрдөнө.	support” буюу санхүүгийн дахин байршуулалтын дэмжлэг нь хөдөлмөрийн зах зээлд эргэн ороход нь дэмжлэг үзүүлэх зорилготой болсон.
	Энэтхэг Нэг хүнд ногдох ДНБ 2,696 US$ (2024)	Парламентын гишүүний тэтгэвэр, тэтгэмж болон цалингийн тухай хууль 8А дугаар зүйл. Тэтгэвэр The Salary, Allowence and Pension of Members of Parliament Act (1954)[25]	Насан туршид нь	2009 оны 5 дугаар сарын 18-наас эхлэн сар бүр 25000 рупи (ойролцоогоор 282 ам.доллар)-ийн тэтгэвэр (pension) авна. Тав ба түүнээс дээш жил ажилласан тохиолдолд жил тутамд 2000 рупи (ойролцоогоор 22.56	- парламентын аль ч танхимд ажиллаж байсан бол	Энэхүү тэтгэврийн тодорхой ажил, албан тушаал эрхэлж байгаа тохиолдолд авахгүй[26]. Гэхдээ дээр дурдсан тохиолдолуудад авч буй цалин хөлс, урамшуулал нь тэтгэврийн хэмжээнээс бага

[24] Олон Улсын Парламентын холбоо (IPU), Швед. Хандах: https://data.ipu.org/parliament/NO/NO-LC01/parliamentary-mandate/parliamentary-mandate/
[25] Энэтхэг: The Salary, Allowence and Pension of Members of Parliament Act (1954). Хандах https://www.mpa.gov.in/sites/default/files/Updated%20version%20of%20MSA%20Act%20and%20rules%20made%20thereunder.pdf#:~:text=8Ad,tax%20Act%2C%201961
[26] (i) Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийн албан тушаалд сонгогдсон, эсхүл аливаа муж улсын Амбан захирагч, холбооны нутаг дэвсгэрийн Захирагчийн албан тушаалд томилогдсон; эсхүл
(ii) Улсын Зөвлөл (Council of States), Ардын Танхим (House of the People), муж улс эсхүл холбооны нутаг дэвсгэрийн хууль тогтоох ассамблей, муж улсын хууль тогтоох зөвлөл, эсхүл 1966 оны Дели удирдлагын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан Дели хотын Зөвлөлд гишүүн болсон; эсхүл

		Section 8A.Pension		ам.доллар) нэмэгдэнэ. Тэтгэврийн хэмжээ таван жил тутам инфляцийн индексээр нэмэгдэнэ.		байвал тэтгэврийн зөрүүг авах эрхтэй.

Эх сурвалж: Судалгаанд хамрагдсан улсуудын хууль тогтоомж, мэдээлэлд тулгуурлан судлаачийн боловсруулснаар.

(iii) Төв засгийн газар, аливаа муж улсын засгийн газарт цалинтай албан тушаал хашиж байгаа, эсвэл Төв болон муж улсын засгийн газрын өмчлөл, хяналт дор байгаа корпорацид ажиллаж байгаа, эсхүл орон нутгийн байгууллагаас цалин, урамшуулал, хөлс авах эрхтэй болсон бол.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Дэлхийн банк. Хандах: https://data.worldbank.org/indicator/NY.GDP.PCAP.CD?locations=AU-AT-DE-GH-DK-IE-CA-NO-SE-GB&name_desc=false&utm_source=chatgpt.com

Австрали: Parliamentary Contributory Superannuation Act 1948, Resettlement Allowance. Хандах: https://publications.parliament.uk/pa/cm5803/cmselect/cmadmin/209/report.html#:~:text=107,are%20entitled%20to%20a%20severance

Commonwealth parliamentarians pay and remuneration: Survey outcome report 2020-2021, https://www.cpahq.org/media/1z3fwmeu/cpa-members-remuneration-report-2020-2021-final.pdf#:~:text=The%20type%20of%20allowance%20is,so%2C%20are%20these%20payments%20taxed

Олон Улсын Парламентын холбоо (IPU). Хандах: https://data.ipu.org/parliament/AU/AU-UC01/parliamentary-mandate/parliamentary-mandate/

Австри: Federal Emoluments Act. Хандах: (1997/2015),https://www.parlament.gv.at/en/explore/making-laws/legal-bases/page/index.html#:~:text=%C2%A7%206,after%20termination%20of%20function

Гана: The Constitution of the Republic of Ghana. Хандах: https://www.icla.up.ac.za/images/constitutions/ghana_constitution.pdf#:~:text=%E2%80%9CGratuties%20for

Герман: *Abgeordnetengesetz,* https://www.gesetze-im-internet.de/abgg/

Deutscher Bundestag, https://www.bundestag.de/abgeordnete/mdb_diaeten/mdb_diaeten-214848?utm_source=chatgpt.com

Дани: Parliamentary Election Act (1988/2016). Хандах: https://www.elections.im.dk/parliament-elections/folketing-parliamentary-elections-act

Loss of office and Transitional Support: Parliamentary comparison (2024). Хандах: https://remunerationboard.wales/media/j1kj3glq/loss-of-office-and-transitional-support-parliamentary-comparison.pdf#:~:text=Denmark%20Provision%20for%20the%20remuneration,35

Ирланд: Termination payments. Хандах: https://www.oireachtas.ie/en/working-in-parliament/pensions/termination-payments/

Их Британи: Members' pay and expenses 2024/25, House of Commons Library research breifing. Хандах: https://researchbriefings.files.parliament.uk/documents/CBP-10225/CBP-10225.pdf#:~:text=of%20service%20subject%20to%20a,There%20would%20be%20remaining

Канад: Pension plan, pay and benefits of departing Members of Parliament and during dissolution of Parliament. Хандах:https://www.ourcommons.ca/Content/Newsroom/Articles/FAQsPensionSalariesBenefits-Dissolution2021-ENG%20(final).pdf

Норвеги: MPs’ pay, allowances and other arrangement. Хандах: https://www.stortinget.no/en/In-English/Members-of-the-Storting/Financial-support/#:~:text=Severance%20pay

Норвеги: Stortinget. Хандах: https://www.stortinget.no/en/In-English/Members-of-the-Storting/Financial-support/#:~:text=Severance%20pay

Энэтхэг: The Salary, Allowence and Pension of Members of Parliament Act (1954). Хандах https://www.mpa.gov.in/sites/default/files/Updated%20version%20of%20MSA%20Act%20and%20rules%20made%20thereunder.pdf#:~:text=8Ad,tax%20Act%2C%201961

International Parliamentary Standarts Authority (IPSA)-The Scheme of MPs’ Staffing and Business Costs 2024-25, Хандах https://assets.ctfassets.net/nc7h1cs4q6ic/5S1XNi2m1uVDWyEqpx3rdv/2afac427cd87da2aa504260951fa43b6/Seventeenth_edition_of_the_Scheme_2024-25.pdf